НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Боловсролын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/150/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал<br>Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br><br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Я.Алтанцэцэг<br>Утас: 315093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Д.Мөнхдэлгэр<br>Утас: 325093 Цахим хаяг: munkhdelgerd@audit.gov.mn<br><br>Аудитор: Д.Эрдэнэбулган<br>Утас: 325093 Цахим хаяг: erdenebulgand@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 195

танай ____________-ны № ______________-т

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
БОЛОВСРОЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЛХАГВАДЭМБЭРЭЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хан-Уул дүүргийн Боловсролын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний эдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 103.7 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны А/324 дүгээр захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 8.7 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

1426050?03

**Бусад асуудал**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 87.8 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **4** | | |
| **32** | **БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | | | |
| **33** | **АВЛАГА** | **5** | **4,959,690.24** | **2,678,139.28** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 4,959,690.24 | 2,678,139.28 |
| 33102 | НДШ-ийн авлага | | 855,791.00 | |
| 33103 | ХАОАТ-ын авлага | | 4,103,899.24 | 2,678,139.28 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | | | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **6** | **46,858,300.00** | **7,108,300.00** |
| 35100 | Түүхий эд материал | | 39,000,000.00 | |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | 39,000,000.00 | |
| 35400 | Хангамжийн материал | | 7,858,300.00 | 7,108,300.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 481,200.00 | 481,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 3,927,200.00 | 3,927,200.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 3,449,900.00 | 2,699,900.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | | | |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)** | | **51,817,990.24** | **9,786,439.28** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | | | |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **7** | **51,035,914.98** | **37,378,944.53** |
| 39200 | Биет хөрөнгө | | 51,035,914.98 | 37,378,944.53 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | | 89,411,067.50 | 89,411,067.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | | (44,007,218.96) | (56,863,389.33) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 12,650,000.00 | 12,650,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | | (7,064,933.56) | (7,865,733.64) |
| 39217 | Номын фонд | | 47,000.00 | 47,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)** | | **51,035,914.98** | **37,378,944.53** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)** | | **102,853,905.22** | **47,165,383.81** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **9** | | **2,686,020.00** |
| 41300 | Өглөг | | | 2,686,020.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | | 1,129,800.00 |
| 41312 | НДШ-ийн өглөг | | | 1,129,800.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | | 385,500.00 |
| 413201 | Бичиг хэргийн өглөг | | | 352,500.00 |
| 413206 | Шуудан холбооны өглөг | | | 33,000.00 |
| 41360 | Бусад өглөг | | | 1,170,720.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | | 1,170,720.00 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **10** | | |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)** | | | **2,686,020.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | **102,853,905.22** | **44,479,363.81** |
| 51101 | -Төрийн | | 14,553,485.00 | 14,553,485.00 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 88,300,420.22 | 29,925,878.81 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 32,236,367.38 | 88,300,420.22 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 56,064,052.84 | (58,374,541.41) |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)** | | **102,853,905.22** | **44,479,363.81** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)** | | **102,853,905.22** | **47,165,383.81** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | | |
| **13** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **701,528,900.00** | **469,230,480.00** |
| 1310 | Улсын төсвөөс | | 327,667,700.00 | 365,501,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 327,667,700.00 | 365,501,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 373,861,200.00 | 103,728,980.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | | 373,861,200.00 | 103,728,980.00 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | | **22,351,901.00** | |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | | 22,351,901.00 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 22,351,901.00 | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2** | **723,880,801.00** | **469,230,480.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **667,816,748.16** | **527,605,021.41** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 647,007,327.16 | 495,171,103.49 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | | 267,976,447.76 | 290,660,483.04 |
| 210101 | Үндсэн цалин | | 152,274,442.76 | 143,837,031.46 |
| 210102 | Нэмэгдэл | | 51,703,320.00 | 73,080,032.72 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | | 42,164,281.00 | 51,819,000.00 |
| 210104 | Урамшуулал | | 21,834,404.00 | 21,924,418.86 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 32,816,391.00 | 39,471,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 22,485,374.00 | 27,186,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 2,489,712.00 | 3,071,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 1,358,665.00 | 1,535,800.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 1,247,361.00 | 1,535,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 5,235,279.00 | 6,142,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 1,808,400.00 | 2,350,920.00 |
| 210304 | Байрны түрээс | | 1,808,400.00 | 2,350,920.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 26,949,850.00 | 45,960,090.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 20,658,500.00 | 6,209,890.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 480,000.00 | 259,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 3,078,000.00 | 491,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 448,700.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 2,284,650.00 | |
| 210409 | Бараа материал шилжүүлсний зардал | | | 39,000,000.00 |
| 2105 | Нормативт зардал | | 3,600,000.00 | 10,200,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 3,600,000.00 | 10,200,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 292,625,000.00 | 6,467,160.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 292,185,600.00 | 5,816,160.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 439,400.00 | 651,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 21,231,238.40 | 100,060,550.45 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 2,775,700.00 | 83,403,580.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | | 7,048,000.00 | 3,000,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | | 11,407,538.40 | 13,656,970.45 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 20,809,421.00 | 32,433,917.92 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 17,140,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 17,140,000.00 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 3,669,421.00 | 32,433,917.92 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 3,669,421.00 | 32,433,917.92 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | | |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **3** | **667,816,748.16** | **527,605,021.41** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | | **56,064,052.84** | **(58,374,541.41)** |
| **14** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО** | | | |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)** | | | |
| **23** | **Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл** | | | |
| **24** | **Гадаад зээлийн үндсэн төлбөр** | | | |
| **25** | **Гадаад валютын ханшийн зөрүү** | | | |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | | | |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | | **56,064,052.84** | **(58,374,541.41)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | |
| **13** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **701,528,900.00** | **469,230,480.00** |
| 1310 | Улсын төсвөөс | 327,667,700.00 | 365,501,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 327,667,700.00 | 365,501,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 373,861,200.00 | 103,728,980.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 373,861,200.00 | 103,728,980.00 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **701,528,900.00** | **469,230,480.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **701,528,900.00** | **469,230,480.00** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 680,719,479.00 | 436,796,562.08 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 272,080,347.00 | 288,804,692.08 |
| 210101 | Үндсэн цалин | 156,378,342.00 | 144,318,661.83 |
| 210102 | Нэмэгдэл | 51,703,320.00 | 69,106,846.39 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 42,164,281.00 | 51,819,000.00 |
| 210104 | Урамшуулал | 21,834,404.00 | 23,560,183.86 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,672,182.00 | 38,342,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,341,165.00 | 26,056,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,489,712.00 | 3,071,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,358,665.00 | 1,535,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,247,361.00 | 1,535,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,235,279.00 | 6,142,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,808,400.00 | 1,620,200.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,808,400.00 | 1,620,200.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,554,800.00 | 1,398,590.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,729,100.00 | 681,390.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 480,000.00 | 259,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,078,000.00 | 458,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 448,700.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,819,000.00 | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 292,625,000.00 | 11,601,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 292,185,600.00 | 11,390,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 439,400.00 | 211,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,978,750.00 | 95,029,580.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 57,930,750.00 | 87,033,580.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,048,000.00 | 7,996,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 20,809,421.00 | 32,433,917.92 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,140,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,140,000.00 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 3,669,421.00 | 32,433,917.92 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,669,421.00 | 32,433,917.92 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)** | **701,528,900.00** | **469,230,480.00** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **14,553,485.00** | | **32,236,367.38** | | **46,789,852.38** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 14,553,485.00 | | 32,236,367.38 | | 46,789,852.38 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | | | | |
| 5 | Тайлант үеийн үр дүн | | | 56,064,052.84 | | 56,064,052.84 |
| 6 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | | | |
| **7** | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **14,553,485.00** | | **88,300,420.22** | | **102,853,905.22** |
| 8 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | |
| 9 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 14,553,485.00 | | 88,300,420.22 | | 102,853,905.22 |
| **10** | **Тайлант үеийн үр дүн** | | | **(58,374,541.41)** | | **(58,374,541.41)** |
| **11** | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **14,553,485.00** | | **29,925,878.81** | | **44,479,363.81** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүнгээр | % |
| **71808** | **Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага** | **365,501,500.00** | **333,067,582.08** | **32,433,917.92** | **91.13** |
| **00000** | **Төрийн сан** | **-** | **-** | **-** | **-** |
| **80101** | **Үндсэн үйл ажиллагааны зардал** | **365,501,500.00** | **333,067,582.08** | **32,433,917.92** | **91.13** |
| **12** | **Татварын бус орлого** | **365,501,500.00** | **333,067,582.08** | **32,433,917.92** | **91.13** |
| **12200** | **Тусламжийн орлого** | **365,501,500.00** | **333,067,582.08** | **32,433,917.92** | **91.13** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 365,501,500.00 | 333,067,582.08 | 32,433,917.92 | 91.13 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **365,501,500.00** | **333,067,582.08** | **32,433,917.92** | **91.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **365,501,500.00** | **333,067,582.08** | **32,433,917.92** | **91.13** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **365,501,500.00** | **333,067,582.08** | **32,433,917.92** | **91.13** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **303,699,100.00** | **288,804,692.08** | **14,894,407.92** | **95.10** |
| 210101 | Үндсэн цалин | 164,509,400.00 | 144,318,661.83 | 20,190,738.17 | 87.73 |
| 210102 | Нэмэгдэл | 96,163,400.00 | 69,106,846.39 | 27,056,553.61 | 71.86 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 23,529,000.00 | 51,819,000.00 | (28,290,000.00) | 220.23 |
| 210104 | Урамшуулал | 19,497,300.00 | 23,560,183.86 | (4,062,883.86) | 120.84 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **38,342,100.00** | **38,342,100.00** | | **100.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,056,300.00 | 26,056,300.00 | | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,071,400.00 | 3,071,400.00 | | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,535,800.00 | 1,535,800.00 | | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,535,800.00 | 1,535,800.00 | | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,142,800.00 | 6,142,800.00 | | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,620,200.00** | **1,620,200.00** | | **100.00** |
| 210304 | Байрны түрээс | 1,620,200.00 | 1,620,200.00 | | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,048,500.00** | **859,590.00** | **10,188,910.00** | **7.78** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,001,900.00 | 681,390.00 | 2,320,510.00 | 22.70 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | | | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,426,700.00 | 178,200.00 | 2,248,500.00 | 7.34 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,513,200.00 | | 1,513,200.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,106,700.00 | | 4,106,700.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж** | **593,600.00** | **211,000.00** | **382,600.00** | **35.55** |
| 210801 | Мэргэжлийн үйлчилгээний төлбөр | | | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 593,600.00 | 211,000.00 | 382,600.00 | 35.55 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **10,198,000.00** | **3,230,000.00** | **6,968,000.00** | **31.67** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 230,000.00 | 230,000.00 | | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал | 9,968,000.00 | 3,000,000.00 | 6,968,000.00 | 30.10 |
| **3** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | | | |
| **31** | **Улсын төсвөөс санхүүжих** | | | | |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | | | | |
| **80802** | **Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг** | **-** | **-** | **-** | **-** |
| **81804** | **Олимпиад зохион байгуулах** | **-** | **-** | **-** | **-** |
| **83603** | **Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан** | **-** | **-** | **-** | **-** |
| **12000** | **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | | | |
| **12100** | **Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | | | | |
| **12200** | **Кассын дансны эцсийн үлдэгдэл** | | | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | | **100.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **10** | **7** | **3** | **70.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9 | 6 | 3 | 66.67 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭ** | **10** | **7** | **3** | **70.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9 | 5 | 4 | 55.56 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 1 | 2 | -1 | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

***/төгрөгөөр/***

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)** | **103,728,980.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **103,728,980.00** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **103,728,980.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **539,000.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 259,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 280,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,390,400.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,390,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **91,799,580.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 86,803,580.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,996,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)** | **103,728,980.00** |
| **13** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **103,728,980.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **103,728,980.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 103,728,980.00 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |

## 3. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Хан-уул дүүргийн Боловсролын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг *“Харьяа нутаг дэвсгэрийнхээ төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд удирдлага, боловсролын мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, иргэдэд боловсролын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, захиргааны оновчтой удирдлага, мэдээллээр хангах, суралцагчийн онцлог, ялгаатай хэрэгцээнд тулгуурлан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, багш, удирдах ажилтны хөгжлийг дэмжих нөхцөлийг сайжруулахад оршино”* гэж тодорхойлжээ.

Тайлант онд дараах зорилтуудыг дэвшүүлэн, хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн явцад хяналт тавьж, сургалтын орчныг сайжруулах;
- Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ тогтмол хийх, сургалтын байгууллагын хөгжлийг чиглүүлэх, үйл ажиллагааны чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
- Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг дүүргийн түвшинд төлөвлөх, зохион байгуулах, төрийн үйлчилгээг шуурхай хүргэх;
- Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргийг хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;
- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана.

## 4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуул-ан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

## 5. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 6. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

## 7. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 388,999.2 мянган төгрөгийн орлогын 14 гүйлгээ, 66,082.9 мянган төгрөгийн зарлагын 8 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 99,709.5 мянган төгрөгийн 4 шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Дүн | 1 | - | | | | | 1 | - | | | | |